



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ЭРХЛЭХ
АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

2017 он



Аудитын код: САГ-2017/12/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261740 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	7
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.7	Шилэн дансны мэдээлэл	9
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	10
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	10
2.9.1	Авлагыг тооцоо нийлж баталгаажуулах талаар	11
2.9.2	Худалдан авах ажиллагааны талаар	11
2.9.3	Анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар	12
2.9.4	Орон тооны талаар	12
2.9.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулах талаар	13
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	13
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	13
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	13
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	14
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
3	Менежментийн захидал	15
3.1	Авлагыг тооцоо нийлж, баталгаажуулах талаар	16
3.2	Худалдан авах ажиллагааны талаар	17
3.3	Анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар	18
3.4	Орон тооны талаар	19
3.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулах талаар	20
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	21
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	21
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	22
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/ өмч өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	23
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	24
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан	25

1 Аудитын гэрчилгээ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 757

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
Н.НОМТОЙБАЯР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн 22,355.2 сая төгрөгийн авлага, 532.3 сая төгрөгийн богино хугацаатай өр төлбөрийг баталгаажуулаагүй, 2,829.3 сая төгрөгийн

бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа холбогдох хууль журам зөрчсөн, 2,200.6 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тус тус тусгасан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн авлага, өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулах, бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх, анхан шатны баримтын бүрдлийг хангах, орон тоог цөөлөх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн

баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 5-наас 2017 оны 4 дүгээр сарын 24-ний хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 1/940 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай”, 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 1 дүгээр хавсралт, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-ын 2 дугаар хавсралт зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

“Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоолын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зохион байгуулалтын бүтцийг баталж үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, энэ чиглэлээр салбар хоорондын зохицуулалт хийх;
- Цалин хөлс, хөдөлмөрийн харилцааны оновчтой тогтолцоо, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурласан мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох, ажиллах хүчний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх;
- Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын хөгжлийг хангах нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзан хүн амын бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах;
- Салбарын хүний нөөц, удирдлагын чадавх, зохион байгуулалтыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилго нь хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 10 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад салбарын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичгийг боловсруулан УСНББОУС, хууль эрх зүйн өөрчлөлтийг тусган шинэчлэн батлуулах, мөн дараах зүйлсийг тусгах шаардлагатай байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөн Сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг Сайдын 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/167 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, дотоод аудитын чиглэлээр 4 мэргэжилтэн ажиллаж байна.

Дотоод аудит, хяналт шалгалтын ажлыг тусгайлсан удирдамжийн дагуу гүйцэтгэсэн. Үүнд:

- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа;
- Хүүхэд харах үйлчилгээний хууль тогтоомжийн хэрэгжилт;
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагаа;
- Хөдөлмөрийн салбарт 2016 онд төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ;
- БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдаж буй “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийн төсөл;

- Олон улсын хүүхдийн Найрамдал төвийн 2013-2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт;
- Олон улсын хүүхдийн Найрамдал төвийн усан спорт цогцолборын барилгын гүйцэтгэлийн явц;
- Монголын Ахмадын чөлөөт холбооны 2016 оны эхний 3 улирлын гэрээт ажлын гүйцэтгэл;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт;

Тайлант хугацаанд 12 байгууллагын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр дүн, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалт, хууль тогтоомж, дүрэм, журам, тушаал шийдвэрийн хэрэгжилтийн байдалд дотоод аудит, хяналт шалгалт хийж 84 зүйл бүхий 2.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж 0.1 сая төгрөгийн актын төлбөр, 0.2 сая төгрөгийн зөрчил арилгах 20 заалт бүхий 6 албан шаардлага, 123 зөвлөмж хүргүүлсэн байна.

Дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдсан байгууллага бүрт санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байгаа нь харьяа байгууллагуудын дотоод аудит, хяналтын удирдлага зохион байгуулалт муу, өгөгдсөн зөвлөмжийн биелэлт хангалтгүй, дотоод хяналт хариуцсан ажилтныг тогтвортой ажиллуулдаггүй зэрэгтэй холбоотой байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын **5** хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 747,295.8 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 719,860.4 сая төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь Сангийн яам улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлын улмаас төлөвлөсөн зарим зардлын эрхийг хязгаарлах бодлоготой холбоотой 27,435.4 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд эргэн төлөгдөх зээл 13,000.0 сая төгрөг олгогдоогүй, хөрөнгийн зардал 6,372.9 сая төгрөг буюу 5.2 хувиар, урсгал шилжүүлэг 4,270.5 сая төгрөг буюу 3.6 хувиар, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1,595.6 сая төгрөг буюу 4.1 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1,167.4 сая төгрөг буюу 16.0 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 338.1 сая төгрөг буюу 3.7 хувиар, нормативт зардал 303.4 сая төгрөг буюу 7.1 хувиар, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 194.9 сая төгрөг буюу 4.7 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 84.5 сая төгрөг буюу 13.9 хувиар, томилолт, зочны зардал 37.5 сая төгрөг буюу 13.5 хувиар, бараа, үйлчилгээний бусад зардал 34.8 сая төгрөг буюу 0.3 хувиар тус тус хэмнэгдсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 137 байгууллага, тусгай сан 5, аймаг нийслэлийн тусгай сан /дэд/ 30, төсөл хөтөлбөр 2, нийт 174 объектын шилэн дансны нэгдсэн сайтад хууль, журмын хүрээнд тайлан, мэдээлэл байршуулсан мэдээллийг авч үзэхэд харьяа байгууллагууд дунджаар 86.6 хувь, төсөл хөтөлбөр 51,6 хувь, тусгай сан дунджаар 89.0 хувьтай ба нэгдсэн дүнгээр 86.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны нэгдсэн сайтад илгээсэн тайлан мэдээллийн нэгтгэл

дд	Байгууллагын нэр	Байгууллагын тоо	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо	Мэдээлээгүй /тоо/				Хэрэгжилт хувиар
					Төсөв/гүйцэтгэл	ХО, тендер, ху/авалт	Бусад	Дүн	
1	Сайд ТЕЗ	1	71	53	10	3	5	18	74.6
2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	1	71	47	7	4	13	24	66.2
3	Харьяа байгууллагууд	9	1,234	866	105	108	155	368	70.2
4	Агентлаг	3	351	303	11	12	25	48	86.3
5	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харьяа байгууллагууд	22	3,224	3,065	87	26	46	159	95.1
6	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа байгууллагууд	33	4,785	4,257	133	135	260	528	89.0
7	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын харьяа байгууллагууд	68	7,684	6,503	357.0	332	492	1,181	84.6
	Дүн	137	17420	15094	710	620	996	2326	86.6
8	Төсөл хөтөлбөр	2	285	147	49	39	50	138	51.6
	Дүн	2	285	147	49	39	50	138	51.6
9	Тусгай сан	5	745	690	14	4	37	55	92.6
10	Аймаг дүүргийн ХЭДСан	30	4260	3764	179	136	181	496	88.4
	Дүн	35	5005	4454	193	140	218	551	89.0
	ТЕЗ-ийн багцын нэгдсэн дүн	174	22710	19695	952	799	1264	3015	86.7

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулахтай холбоотой гарч буй нийтлэг зөрчил:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан тайлан мэдээллийг нэгтгэх явцад ТЕЗ-ийн багцад хамаарах Өнөр бүл хүүхдийн төв нь Нийслэлийн ТЕЗ-д хамаарсан;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д хамаарах төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагууд шилэн дансны нэгдсэн сайтад бүртгэлтэй боловч мэдээлэл оруулаагүй байна.
- Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлэх ба ихэнх байгууллага мэдээлээгүй, шилэн дансны нэгдсэн сайтад илгээсэн тайлан мэдээлэлгүй хоосон байна.

- Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр оруулсан боловч шалтгаан тайлбарыг мэдээлээгүй байна.
- Цахим сайтад байршуулсан PDF файлууд нь нээгдэхгүй байх, нээгдсэн ч уншигдахгүй байх, үсэг фонт нь танигдахгүй байх, хуульд заасан хугацаа хэтрүүлэн мэдээлсэн зэрэг зөрчил нийтлэг байгаа нь хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмуудыг хангахгүй байна.
- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагуудын дотоод хяналт сул байгаагаас мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны нэгдсэн сайтад тайлан, мэдээлэл байршуулсан байдлыг хэрэгжилтийн хувиар авч үзвэл огт оруулаагүй 1 байгууллага, 24-50 хүртэл хувьтай 8 байгууллага, 50-70 хувьтай 16 байгууллага, 70-80 хувьтай 16 байгууллага, 80-100 хүртэл хувьтай тайлан мэдээллээ байршуулсан 96 байгууллага байна. Үүнээс үзвэл, харьяа байгууллагуудын 70.1 хувь нь шилэн дансны нэгдсэн сайтад тайлан мэдээллээ тогтмол байршуулж хэвшсэн байна. Үүнд: БНСУ дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь шилэн дансны нэгдсэн сайтад бүртгэлтэй боловч мэдээлэл оруулаагүй байна.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 4, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг 22, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехникийн коллеж 37, төсвийн шууд захирагч 9, төсөл, хөтөлбөр 5, жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв 5, бусад 5, нийт 87 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нэгтгэгдсэн болно.

2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад нийт 76 байгууллага хамрагдаж 19.9 хувь буюу 7 нэгжийг Үндэсний аудитын газар, 3.4 хувь буюу 21 нэгжийг аймгийн аудитын газрууд, 3.0 хувь буюу 18 нэгжийг аудитын компаниуд гэрээлэн аудит хийж дүгнэлт гаргасан байна.

Мөн 0.3 хувь буюу 2 нэгжийн санхүүгийн тайланд итгэмжлэх олгож, 72.0 хувь буюу 28 нэгжийг Үндэсний аудитын газар түүвэрт хамруулсан болно.

Үйл ажиллагаа явуулаагүй 2 нэгж, аудитад хамрагдаагүй 9 нэгж байгаа нь сайдын төсвийн багцын дүнд тус бүр 0.7 хувь эзэлж байна.

Санхүүгийн тайланд 47 байгууллага зөрчилгүй, 9 байгууллага хязгаарлалттай дүгнэлт авсан байна. Тухайлбал: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор, Булган, Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Говьсүмбэр дэх болон Монгол-Солонгосын Политехникийн коллеж санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт авсан байна.

2.9.1 Авлагыг тооцоо нийлж баталгаажуулах талаар

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын СНТ-гаар 2016 онд 100,275.9 сая төгрөгийн авлага, 10,201.4 сая төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 22,186.7 сая, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв 140.4 сая, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор 124.8 сая, Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын төв 42.4 сая, 4 аймгийн МСҮТ 43.2 сая, нийт 22,355.2 сая төгрөгийн авлага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв 313.1 сая, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 190.9 сая, нэр бүхий 6 МСҮТ 28.3 сая, нийт 532.3 сая төгрөгийн богино хугацаатай өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлж, тайлант хугацааны эцэст авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан тайланд тусгаж хэвших;

2.9.2 Худалдан авах ажиллагааны талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас худалдан авах ажиллагааны тендер зарлалгүй 11 байгууллагатай 90.0-290.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, нийт 1,872.3 сая төгрөгийн, "Босго үнэ тогтоох тухай" Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын дагуу 880.3 сая төгрөгийн худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглаагүй байна. Тухайлбал:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 16 байгууллагатай 743.3 сая төгрөгийн ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ Төрийн бус байгууллагатай хийсэн,
- Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор Харшийн сүлд модны наадамд оролцсон хүүхдүүдэд зориулан 84.8 сая төгрөгийн бэлэг худалдан авсан,

- Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв нь 52.2 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийсэн,

Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв нь Алтай инженеринг, Хөх судар ХХК-уудтай 161.4 сая төгрөгийн бараа материал нийлүүлэх гэрээ байгуулснаас гэрээний хугацаанд 76.6 сая төгрөгийн бараа материал дутуу нийлүүлсэн байна.

Худалдан авах ажиллагаатай холбоотой 2,829.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-д "Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол болон нийлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээний зүйл заалтыг үйл ажиллагаандаа бүрэн мөрдөж, худалдан авах ажиллагааны зөрчилгүй ажиллах;

2.9.3 Анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар

Ажил үйлчилгээ үзүүлсэн анхан шатны баримт, гүйцэтгэсэн ажлын тайлан, санхүүгийн баримт дутуу 2,200.6 сая төгрөгийг санхүүгийн тайланд тусгасан байна. Тухайлбал:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 1,374.8 сая,
- Орхон аймаг дахь МСҮТөв 561.8 сая,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв 160.6 сая,
- Яамны аппарат 38.1 сая,
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 35.9 сая,
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 23.7 сая,
- Орхон аймаг дахь ХАА-н МСҮТөв 3.6 сая,
- Хэнтий аймаг дахь МСҮТөв 2.1 сая төгрөг,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөж, анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгаж ажиллах;

2.9.4 Орон тооны талаар

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын холбогдох тушаалуудаар харьяа агентлаг, байгууллагын зохион байгуулалт, бүтэц, орон тоог баталсан байна. Үүнд:

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 1 дарга, 2 дэд дарга,
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар 1 дарга, 2 дэд дарга,
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 1 дарга, 1 дэд дарга,
- Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор 1 захирал, 2 дэд захирал,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв 1 захирал, 2 дэд захирал,

- Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийг 1 дарга, 1 дэд даргатай байхаар баталж үйл ажиллагаа явуулж байгаа нь Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 3-т “бүх шатны Засаг даргын орлогч, төсөвт байгууллагын дэд дарга, яам, агентлагийн газрын орлогч дарга, даргын туслах, төсвөөс цалинждаг зөвлөх зэрэг орон тоог цөөлөх, цомхотгох” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.
Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллах, зөвлөмж хүргүүлэх;

2.9.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулах талаар

Тус яам шинээр зохион байгуулагдсанаар УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг бүрэн мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх, зөвлөмж хүргүүлэх;

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитын явцад:

- Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж буй Сангийн яамны “Э-тайлан” програм хангамж хэвийн ажиллаагүй,
 - Төрийн сангийн газраас ирүүлсэн ТЕЗ болон Сангийн яам хоорондын тооцоо нийлсэн баримтад хөрөнгийн санхүүжилт, зардлын гүйлгээг тусгаагүй,
 - Төв төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй, нэгтгэлийн “Э-тайлан” програмаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хувь оролцооны дүн дутуу татагдсан байна.
- Эдгээр нь ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг ЗГСНТ-д нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсгэх магадлалтай байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад татан буугдсан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хаалтын санхүүгийн тайлан хамрагдаагүйг анхаарч нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 61,085.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 57,839.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 862.6 сая төгрөгийн 25

төлбөрийн акт, 983.0 сая төгрөгийн 25 албан шаардлага тавьж, 1,399.7 сая төгрөгийн 193 зөвлөмж өгсөн.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдад 4, Хөдөлмөрийн сайдад 2 зөвлөмж өгөгдсөн байна. Хөдөлмөрийн сайдад өгөгдсөн зөвлөмжийг бүрэн биелүүлж, Хүн амын хөгжил, нийгмийн хөгжлийн сайдад өгөгдсөн зөвлөмж 50.0 хувийн биелэлттэй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 729,729.0 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь 7,297.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн 22,355.2 сая төгрөгийн авлага, 532.3 сая төгрөгийн богино хугацаатай өр төлбөрийг баталгаажуулаагүй, 2,829.3 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа холбогдох хууль, журам зөрчсөн, 2,200.6 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тус тус тусгасан байна.

Энэ нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Авлагыг тооцоо нийлж, баталгаажуулах талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын СНТ-гаар 2016 онд 100,275.9 сая төгрөгийн авлага, 10.201.4 сая төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 22,186.7 сая, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв 140.4 сая, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор 124.8 сая, Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын төв 42.4 сая, 4 аймгийн МСҮТ 43.2 сая, нийт 22,355.2 сая төгрөгийн авлага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв 313.1 сая, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 190.9 сая, нэр бүхий 6 МСҮТ 28.3 сая, нийт 532.3 сая төгрөгийн богино хугацаатай өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигдөж, үнэн зөв, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд зөрчигдөх:

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлж, тайлант хугацааны эцэст авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан тайланд тусгаж хэвших;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

3.2 Худалдан авах ажиллагааны талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас худалдан авах ажиллагааны тендер зарлалгүй 11 байгууллагатай 90.0-290.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, нийт 1,872.3 сая төгрөгийн, “Босго үнэ тогтоох тухай” Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын дагуу 880.3 сая төгрөгийн худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглаагүй, Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв нь Алтай инженеринг, Хөх судар ХХК-уудтай 161.4 сая төгрөгийн бараа материал нийлүүлэх гэрээ байгуулснаас гэрээний хугацаанд 76.6 сая төгрөгийн бараа материал дутуу нийлүүлсэн байна.

Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой 2,829.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-д "Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, өндөр үнэтэй бараа материал бэлтгэх

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол болон нийлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээний зүйл заалтыг үйл ажиллагаандаа бүрэн мөрдөж, худалдан авах ажиллагааны зөрчилгүй ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

3.3 Анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Ажил үйлчилгээ үзүүлсэн анхан шатны баримт, гүйцэтгэсэн ажлын тайлан, санхүүгийн баримт дутуу 2,200.6 сая төгрөгийг санхүүгийн тайланд тусгасан байна. Тухайлбал:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 1,374.8 сая,
- Орхон аймаг дахь МҮСТөв 561.8 сая,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв 160.6 сая,
- Яамны аппарат 38.1 сая,
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 35.9 сая,
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 23.7 сая,
- Орхон аймаг дахь ХАА-н МҮСТөв 3.6 сая,
- Хэнтий аймаг дахь МҮСТөв 2.1 сая төгрөг,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

Эрсдэлүүд

Бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийх, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв" байх батламж зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөж, анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгаж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

3.4 Орон тооны талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын холбогдох тушаалуудаар харьяа агентлаг, байгууллагын зохион байгуулалт, бүтэц, орон тоог баталсан байна. Үүнд:

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 1 дарга, 2 дэд дарга,
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар 1 дарга, 2 дэд дарга,
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 1 дарга, 1 дэд дарга,
- Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор 1 захирал, 2 дэд захирал,
- Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв 1 дарга, 1 дэд дарга,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийг 1 захирал, 2 дэд захиралтай байхаар баталж үйл ажиллагаа явуулж байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 3-т “бүх шатны Засаг даргын орлогч, төсөвт байгууллагын дэд дарга, яам, агентлагийн газрын орлогч дарга, даргын туслах, төсвөөс цалинждаг зөвлөх зэрэг орон тоог цөөлөх, цомхотгох” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Засгийн газрын тогтоол шийдвэрүүд хэрэгжихгүй байх, орон тоо, зардал хэтрэх,

ҮАГ-ын зөвлөмж

Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

**3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын
бичиг баримт боловсруулах талаар**

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Тус яам шинээр зохион байгуулагдсанаар УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг бүрэн мөрдөөгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан нэгдсэн стандарт журмын дагуу илэрхийлэгдэхгүй байх

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Балансын үзүүлэлт	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		119,879,432.1
МӨНГӨН ХӨРӨНГӨ		6,571,926.8
АВЛАГА		100,275,916.8
УРЬДЧИЛГАА		150,025.5
БАРАА МАТЕРИАЛ		12,881,563.1
НӨӨЦИЙН БАРАА		-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		204,117,220.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ		204,117,220.3
Биет хөрөнгө		203,020,891.0
Биет бус хөрөнгө		1,096,329.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		323,996,652.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР		10,201,460.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		6,409,824.6
Богино хугацаат зээлийн өглөг		1,170,542.6
Өглөг		5,160,195.0
Урьдчилж орсон орлого		79,087.0
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		3,791,635.4
Урт хугацаат зээл		3,791,635.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		313,795,192.4
Засгийн газрын хувь оролцоо		313,795,192.4
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		81,987,183.0
Хуримтлагдсан үр дүн		195,450,779.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		36,357,229.9
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		323,996,652.4

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		796,504,188.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		120,446,949.8
Нийтлэг татварын бус орлого		120,446,949.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		676,057,238.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		729,729,045.4
УРСГАЛ ЗАРДАЛ		704,397,162.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		94,222,718.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		39,151,637.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,186,743.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		8,975,379.6
Хангамж, бараа материалын зардал		2,011,850.5
Нормативт зардал		4,701,986.9
Эд хогшил, урсгал засварын зардал		1,297,741.1
Томилолт, зочны зардал		462,452.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,248,396.8
Бараа үйлчилгээний бусад зардал		27,186,092.2
ТАТААС		494,879,039.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		115,295,404.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		25,331,883.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		66,775,143.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		2,188,211.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		930,571.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		1,257,639.7
НИЙТ ҮР ДҮН		68,032,782.8

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/ өмч өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	245,865,822.3		245,865,822.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,865,822.3	-	245,865,822.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(103,412.6)		(103,412.6)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-		-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-		-
Тайлант үеийн үр дүн	68,032,782.8		68,032,782.8
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	313,795,192.4	-	313,795,192.4

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		779,366,708.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		102,937,732.7
Нийтлэг татварын бус орлого		102,937,732.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		676,428,975.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		736,369,854.1
УРСГАЛ ЗАРДАЛ		736,369,854.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		79,224,572.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		38,850,337.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,042,847.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,377,718.8
Хангамж, бараа материалын зардал		1,530,625.9
Нормативт зардал		4,875,452.7
Эд хогшил, урсгал засварын зардал		1,073,328.1
Томилолт, зочны зардал		484,190.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,359,889.1
Бараа үйлчилгээний бусад зардал		12,629,744.0
ТАТААС		494,879,039.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		162,266,242.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		42,996,854.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		36,424,927.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		36,424,927.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(36,424,927.7)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		42,996,854.5
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		6,571,926.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,571,926.8

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	747,295,819.7	719,860,442.1	(27,435,377.6)	96.3
УРСГАЛ ЗАРДАЛ	692,368,350.2	684,305,875.8	(8,062,474.4)	98.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,690,083.1	73,898,073.8	(3,792,009.3)	95.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,976,824.5	37,381,188.5	(1,595,636.0)	95.9
Үндсэн цалин	37,408,263.9	36,013,698.5	(1,394,565.4)	96.3
Нэмэгдэл	156,905.6	168,484.1	11,578.5	107.4
Унаа хоолны хөнгөлөлт	1,321,446.3	1,115,507.5	(205,938.8)	84.4
Гэрээт ажлын хөлс	90,208.7	83,498.5	(6,710.2)	92.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,119,632.2	3,924,747.5	(194,884.7)	95.3
Тэтгэврийн даатгал	2,648,710.7	2,655,002.6	6,291.9	100.2
Тэтгэмжийн даатгал	294,290.0	248,831.6	(45,458.4)	84.6
ҮОМШӨ-ний даатгал	367,685.7	315,591.6	(52,094.1)	85.8
Ажилгүйдлийн даатгал	73,485.4	71,886.2	(1,599.2)	97.8
Эрүүл мэндийн даатгал	735,460.4	633,435.5	(102,024.9)	86.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,225,249.9	8,887,184.4	(338,065.5)	96.3
Гэрэл, цахилгаан	1,224,167.6	1,167,846.0	(56,321.6)	95.4
Түлш, халаалт	6,919,284.9	6,763,931.5	(155,353.4)	97.8
Цэвэр, бохир ус	792,492.1	660,773.6	(131,718.5)	83.4
Байрны түрээс	289,305.3	294,633.3	5,328.0	101.8
Хангамж, бараа материалын зардал	1,286,271.4	1,250,351.8	(35,919.6)	97.2
Бичиг хэрэг	247,792.4	258,912.7	11,120.3	104.5
Тээвэр, шатахуун	381,772.6	381,459.9	(312.7)	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	341,730.2	284,911.1	(56,819.1)	83.4
Ном, хэвлэл	2,175.0	2,059.1	(115.9)	94.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	39,609.8	32,812.4	(6,797.4)	82.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	273,191.4	290,196.6	17,005.2	106.2
Нормативт зардал	4,251,149.8	3,947,703.4	(303,446.4)	92.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	585,334.1	528,641.3	(56,692.8)	90.3
Хоол, хүнс	3,301,764.1	3,057,919.2	(243,844.9)	92.6
Нормын хувцас, зөөлөн эдлэл	364,051.6	361,142.9	(2,908.7)	99.2
Эд хогшил, урсгал засварын зардал	606,488.2	521,965.4	(84,522.8)	86.1
Багаж, техник, хэрэгсэл	130,095.1	89,261.0	(40,834.1)	68.6
Тавилга	68,583.8	63,906.4	(4,677.4)	93.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	28,117.3	22,638.9	(5,478.4)	80.5
Урсгал засвар	379,692.0	346,159.1	(33,532.9)	91.2
Томилолт, зочны зардал	278,066.9	240,524.5	(37,542.4)	86.5
Дотоод албан томилолт	278,066.9	240,524.5	(37,542.4)	86.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,311,592.9	6,144,445.6	(1,167,147.3)	84.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,639,872.5	5,633,494.2	(1,006,378.3)	84.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,565.8	133,108.8	(11,457.0)	92.1
Даатгалын үйлчилгээ	77,426.5	57,121.0	(20,305.5)	73.8

Тээврийн хэрэгслийн татвар	24,202.8	18,694.8	(5,508.0)	77.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	5,611.0	4,943.7	(667.3)	88.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	119,821.1	106,786.8	(13,034.3)	89.1
Газрын төлбөр	11,981.0	9,514.9	(2,466.1)	79.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,587.9	2,749.6	(2,838.3)	49.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	282,524.3	178,031.8	(104,492.5)	63.0
Бараа үйлчилгээний бусад зардал	11,634,807.3	11,599,962.8	(34,844.5)	99.7
Бараа үйлчилгээний бусад зардал	3,677,475.3	3,679,909.8	2,434.5	100.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,957,332.0	7,920,053.0	(37,279.0)	99.5
ТАТААС	494,879,039.0	494,879,039.0	-	100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	494,879,039.0	494,879,039.0	-	100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	494,879,039.0	494,879,039.0	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119,799,228.1	115,528,763.0	(4,270,465.1)	96.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	32,229,072.9	31,977,732.2	(251,340.7)	99.2
Засгийн газрын дотоод шилжүүлэг	32,166,172.9	31,915,640.6	(250,532.3)	99.2
Засгийн газрын гадаад шилжүүлэг	62,900.0	62,091.5	(808.5)	98.7
Бусад урсгал шилжүүлэг	87,570,155.2	83,551,030.8	(4,019,124.4)	95.4
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,832.0	5,022.0	(810.0)	86.1
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	34,862,260.0	33,388,565.0	(1,473,695.0)	95.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,703,015.5	2,514,360.0	(188,655.5)	93.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,358,027.0	45,074,628.8	(2,283,398.2)	95.2
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	5,000.0	4,854.4	(145.6)	97.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,084,724.6	1,057,503.5	(27,221.1)	97.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,551,296.1	1,506,097.1	(45,199.0)	97.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,927,469.5	35,554,566.4	(6,372,903.1)	84.8
Дотоод эх үүсвэрээр	41,927,469.5	35,554,566.4	(6,372,903.1)	84.8
Барилга байгууламж	31,541,156.0	30,330,440.2	(1,210,715.8)	96.2
Их засвар	232,000.0	231,429.0	(571.0)	99.8
Тоног төхөөрөмж	10,154,313.5	4,992,697.1	(5,161,616.4)	49.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	13,000,000.0	-	(13,000,000.0)	-
Эргэж төлөгдөх зээл	13,000,000.0	-	(13,000,000.0)	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	747,295,819.7	717,426,746.9	(29,869,072.8)	96.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	674,255,614.3	668,350,098.3	(5,905,516.0)	99.1
Улсын төсвөөс санхүүжих	674,255,614.3	668,350,098.3	(5,905,516.0)	99.1
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	368,000.0	368,000.0	-	100.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	368,000.0	368,000.0	-	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	67,512,891.9	48,708,648.6	(18,804,243.3)	72.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,347,586.9	42,033,679.0	2,686,092.1	106.8
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,478,605.0	2,225,519.4	(9,253,085.6)	19.4
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	11,723,000.0	-	(11,723,000.0)	-
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,963,700.0	4,449,450.1	(514,249.9)	89.6
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	5,159,313.5	-	(5,159,313.5)	-
Хандив тусламж /гадаад/	5,159,313.5	-	(5,159,313.5)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,547,401.6	6,546,932.3	(469.3)	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	125	118	-7	94.4

Төсвийн байгууллага	80	80	0	100.0
Төсвөөс гадуур байгууллага	45	38	-7	84.4
АЖИЛЛАГСАДЫН ТОО	5126	5066	-60	98.8
Удирдах ажилтан	194	171	-23	88.1
Гүйцэтгэх ажилтан	3590	3556	-34	99.1
Үйлчлэх ажилтан	1288	1294	6	100.5
Гэрээт ажилтан	54	45	-9	83.3
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	44464	38083	-6381	85.6
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	44464	38083	-6381	85.6
Төрийн өмчит МСҮТ	29370	26613	-2757	90.6
Хувийн МСҮТ	15094	11470	-3624	76.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	5126	5066	-60	98.8
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1388	1346	-42	97.0
Ажлын албаны албан хаагч (АА)	4	4	0	100.0
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	1867	1873	6	100.3
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	83	83	0	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1754	1736	-18	99.0
Гэрээт ажилтан	28	22	-6	78.6
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	0	100.0